



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/426

Зуунмод

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод хотын шинэ төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хашаа, барилга байгууламжаа чөлөөлсөн хавсралтад дурьдагдсан 5 иргэнд Номт 1-р баг, Соёл хотхонд хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу амины орон сууцны зориулалтаар 0,1 га газрыг суурь үнээр нь эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч нарт дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах.

2.2. Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.4. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, архитектур төлөвлөлтийн дагуу барилга байгууламж барих,

2.5. Газрын суурь үнэ $1\text{м}^2=4000$ төгрөгөөр тооцож, төлбөрийг төсөвт төвлөрүүлэх.

3. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/ нарт дараах ажлыг үүрэг болгосугай.

3.1. Газар эзэмшигчтэй гэрээ байгуулж дүгнэж ажиллах.

3.2. Газрын мэдээллийн санд бүртгэж, гэрчилгээг олгох.

3.3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

010 31289

Нийт